# 17.1 Тайлан харах /дүнгийн хавтай/

Тайлан хэрхэн харах дараалал

Уг тайлан буюу дүнгийн хавтгайг цахим журнал ашиглаж буй сургуулийн хувьд 3-12-р ангийн хувьд Үнэлгээ-2 батлагдсан дүнгээр, 1-2-р ангийн хувьд Үнэлгээ-1 дээр оруулсан буюу чадварын тоог тоолж нэгдсэн байдлаар  харж болно.

1. Дүнгийн нэгтгэл 3-12-р анги – Нэг бүлгийн хувьд бүх ээлжит хичээлийн Үнэлгээ-2 батлагдсанаар 1-р хагас жил болон 2-р хагас жил /жилийн эцэс/-ээр тус тусд нэгтгэж харуулна.
2. Дүнгийн нэгтгэл 1-2-р анги – Нэг бүлгийн хувьд бүх  ээлжит хичээлийн Үнэлгээ-1 бүртгэсэн чадварыг тоолж 1-р хагас жил болон 2-р хагас жил /жилийн эцэс/-ээр тус тусд нэгтгэж харуулна.
3. Суралцагчийн дүнгийн нэгтгэл-  Тухайн нэг суралцагчийн судалсан бүх хичээлийн 1,2-р хагас жилээр зэрэгцүүлж харуулна.
4. Хичээлийн дүнгийн нэгтгэл – Тухайн нэг багшийн заадаг ээлжит хичээл тус бүрээр Үнэлгээ-2 ийн 1,2-хагас жилээр зэрэгцүүлж харуулна.
5. Суралцагчийн үнэлгээ, дүнгийн хуудас  - Тухайн нэг суралцагчийн судалдаг бүх хичээлийн жагсаалтаар ирцийн хувь болон Үнэлгээ-1 буюу явцын үнэлгээний жагсаалтыг 1,2-р хагас жилийн үнэлгээтэй зэрэгцүүлж харуулна.
6. Хичээлийн үнэлгээ, дүнгийн хуудас – Тухайн нэг ээлжит хичээлийн хувьд суралцагч тус бүрээр бүртгэсэн ирц , үнэлгээг нэгтгэж харуулна.

***Менежерийн эрх:***

Боловсролын удирдлага – Тайлан 

уг цэснээс дүнгийн хавтгайг сургуулийн хэмжээнд харж болно.

1. Аль төрлийн тайланг харах гэж байгааг сонгоно




2. Тайлан төрлөөс хамаарч Мэдээлэл хэсэгт /улаанаар тэмдэглэсэн/ хийх сонголт өөрчлөгдөнө.